



СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



2025 VIII

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



www.sukhbaatar.nso.mn

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН
ТАНИЛЦУУЛГА

2025
8 сар

Баруун-Урт сум

ЕРӨНХИЙ ТЭМДЭГЛЭЛ

I. Товчилсон үгийн тайлал.

- Сумдын нэр:
 - АС Асгат
 - БД Баяндэлгэр
 - ДА Дарьганга
 - МХ Мөнххаан
 - НА Наран
 - ОН Онгон
 - СҮ Сүхбаатар
 - ТШ Түвшинширээ
 - ТЦ Түмэнцогт
 - УБ Уулбаян
 - ХА Халзан
 - ЭЦ Эрдэнэцагаан
 - БУ Баруун-Урт
- 'Төл' гэсэн нь төлөвлөгөө, 'Гүйц' гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-X ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

... Мэдээлэл байхгүй - Гүйцэтгэл байхгүй
0.0 Маш бага тоо * Урьдчилсан гүйцэтгэл
¹ Дахин

а^x х нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь өөрчлөлт

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

- | | | | |
|----------|------------------|-------------------|------------------|
| • мянга | =1000 | • м ² | метр квадрат |
| • сая | =10 ⁶ | • км ² | километр квадрат |
| • тэрбум | =10 ⁹ | • м ³ | метр куб |
| • см | сантиметр | • мл | миллилитр |
| • дм | дециметр | • л | литр |
| • м | метр | • г | грамм |
| • км | километр | • кг | килограмм |
| • мян. | мянга | • цн | центнер |
| • % | хувь | • т | тонн |
| • кВт.ц | киловатт цаг | • ш | ширхэг |
| • ккал | килокалори | | |

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

	Ерөнхий тэмдэглэл	2
	Үндсэн үзүүлэлтүүд	4
I	Хүн ам	5
II	Хөдөлмөр	6
III	Нийгмийн халамж	8
IV	Эрүүл мэнд	10
V	Гэмт хэрэг	12
VI	Мөнгө, банк	13
VII	Орон нутгийн төсөв	14
VIII	Үнэ	15
IX	Хөдөө аж ахуй	20
X	Аж үйлдвэр	22
	Хавсралт хүснэгтийн жагсаалт	26
	Хавсралт хүснэгтүүд	28

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Жил			Сар			Өөрчлөлт	
		2022	2023	2024	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	Дүн	Хувь
ХӨДӨЛМӨР									
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	363	302	234	81	209	386	177	84.7
НИЙГМИЙН ХАЛАМЖ									
Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон дүн	сая.төг	11 093.1	13 019.8	16 461.7	8 290.8	10 867.8	12 745.8	1 878.0	17.3
Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид	хүн	27 369	29 221	29 423	24 056	25 813	20 948	-4 865	-18.8
ЭРҮҮЛ МЭНД									
Амьд төрсөн хүүхэд	хүн	1 110	1 213	955	852	679	555	- 124	-18.3
Амаржсан эх	хүн	1 112	1 209	949	848	673	555	- 118	-17.5
Нас баралт	хүн	294	298	336	205	226	210	- 16	-7.1
1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	хүн	9	6	7	4	5	5	-	-
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	хүн	4	5	3	5	2	1	- 1	-50.0
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	5 369	924	617	763	473	601	128	27.1
ГЭМТ ХЭРЭГ									
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	511	456	497	338	340	398	58	17.1
Хэрэгт холбогсод	хүн	409	328	343	274	230	243	13	5.7
МӨНГӨ, БАНК									
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	133.9	145.2	175.5	136.5	161.6	168.4	6.8	4.2
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	191.6	232.1	307.6	231.6	298.6	327.7	29.1	9.7
ОРОН НУТГИЙН ТӨСӨВ									
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	62.9	82.8	103.3	48.8	69.4	61.1	- 8.3	-12.0
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	52.0	64.5	83.8	32.3	52.0	54.3	2.3	4.4
ҮНЭ									
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	12.7	7.1	7.6	0.0	3.5	3.6	0.1	
АЖ ҮЙЛДВЭР									
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн *	тэрбум төгрөг	149.8	221.3	299.9	132.5	165.1	224.9	59.8	36.2
Борлуулсан бүтээгдэхүүн *	тэрбум төгрөг	322.8	432.1	447.7	302.6	251.1	339.0	87.9	35.0
ГАЗАР ТАРИАЛАН									
Тариалсан талбай: -Үр тариа	га	4 099.0	4 150.0	3 868.0	4 150.0	3 868.0	5 140.0	1 272.0	32.9
-Тэжээлийн ургамал	га	817.0	1 251.6	2 218.5	1 253.6	2 218.5	2 083.5	- 135.0	-6.1
-Техникийн ургамал	га	2 050.0	1 890.0	3 220.0	1 890.0	3 220.0	6 270.0	3 050.0	1.9**
-Төмс	га	75.7	91.2	64.7	91.2	64.7	60.7	- 4.0	-6.2
-Хүнсний ногоо	га	50.1	68.2	48.7	68.2	48.7	47.2	- 1.5	-3.1
Хураасан ургац: -Үр тариа	тн	3 478.0	2 865.0	2 395.0	-	-	50.0	50.0	-
- Төмс	тн	585.8	612.7	531.9	24.6	52.4	53.5	1.1	2.1
-Хүнсний ногоо	тн	872.2	1 060.6	569.2	25.8	24.9	37.2	12.3	49.4

Тайлбар: ** дахин



ХҮН АМ

Төрсөн хүүхдийн тоо өмнөх оноос 18.3 хувиар буурчээ.

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээллээр 2025 оны эхний 8 дугаар сард 555 эх амаржиж, 555 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 118 (17.5%)-аар, төрсөн хүүхэд 124 (18.3%)-өөр тус тус буурчээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар



1000 хүнд ногдох төрөлт өмнөх оны мөн үеэс 1.9 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар



2025 оны эхний 8 дугаар сард нас баралт 210 болж, өмнөх оны мөн үеэс 16 (7.1%)-аар буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 8.4, нас баралт 3.2, ердийн цэвэр өсөлт 5.2 байна.

1000 хүнд ногдох нас баралт өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар



ХӨДӨЛМӨР


Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 84.7 хувиар өсжээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2025 оны 8 дугаар сарын эцэст 386 болсны 203 (52.6%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 177 (84.7%) хүнээр, 2024 оны 12 дугаар сараас 152(65.0%) хүнээр тус тус өссөн байна.

2025 оны эхний 8 дугаар сарын байдлаар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 1141 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 555 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

ЗУРАГ 3.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар



Ажилгүй иргэдийн 247 (63.9%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 3 (0.2%) нь магистр, доктор, 44 (11.3%) нь бакалавр, 12 (3.0%) нь тусгай мэргэжлийн дунд, 13 (3.2%) нь мэргэжлийн анхан шат, 150 (40.1%) нь бүрэн дунд, 94 (24.0%) нь суурь, 53 (13.4%) нь бага, 17 (4.4%) боловсролгүй хүмүүс байна.

ЗУРАГ 4.

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшнээр, 2025 оны 8 дугаар сарын эцэст



Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээ



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ өмнөх оноос 1.1 (1.7%) сая төгрөгөөр өслөө.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2025 оны эхний 8 дугаар сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 1.5 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 30 (2.0%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 4.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.6 (14.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2025 оны эхний 8 дугаар сард 3.0 мянган хүн хамрагдсаны 50.4 хувь нь асаргааны тэтгэмжид, 49.6 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна.

2025 оны эхний 8 дугаар сард нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 12.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 1.9 (17.3%) тэрбум төгрөгөөр өсөж, 20.9 мянган хүн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 4.9 (18.8%) мянган хүнээр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, ТӨРЛӨӨР

Үзүүлэлт	2023 I-VIII		2024 I-VIII		2025 I-VIII		Өөрчлөлт	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Дүн	Хувь
Бүгд	24 056	8 290.8	25 813	10 867.8	20 948	12 745.8	1 878.0	17.3
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	4 744	5 122.4	4 885	7 744.3	5 169	8 926.2	1 181.9	15.3
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 423	3 206.2	1 489	4 052.1	1 519	4 631.4	579.3	14.3
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 310	1 803.0	2 694	3 595.5	2 982	4 231.0	635.5	17.7
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	962	73.5	685	62.7	668	63.8	1.1	1.7
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	5 795	747.7	5 967	759.9	6 237	1 564.8	804.9	2.1 ¹
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	4 798	309.3	5 994	250.8	1 129	237.2	-13.6	-5.4
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	7	0.8	8	1.5	8	2.1	0.6	41.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	369	91.9	536	122.9	410	98.8	-24.1	-19.6
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	5 094	1 519.3	4 732	1 451.3	4 105	1 343.9	-107.4	-7.4
Насны хишиг	3 249	499.5	3 691	537.0	3 890	572.8	35.8	6.7

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 668 хүн хамрагдсан нь өмнөх оноос 17 (2.5%) хүнээр буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

Халамжаас хөдөлмөрт гэсэн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд Асгат, Наран, Сүхбаатар, Халзан, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян сумд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдахаа байсан.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын газрын нийгмийн даатгалын орлого, зарлагын улирлын мэдээ, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын халамжийн сарын мэдээ



ЭРҮҮЛ МЭНД

2025 оны эхний 8 дугаар сарын байдлаар эхийн эндэгдэл гараагүй.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2025 оны эхний 8 дугаар сард 555 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 118 (17.5%) эхээр буурсан байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 483 (87.0%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан, 22 (4.0%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	Өөрчлөлт	
	Тоо			Дүн	Хувь
Амаржсан эх	848	673	555	- 118	-17.5
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	824	633	515	- 118	-18.6
Гэрийн төрөлт	3	2	2	-	-
Амьд төрсөн хүүхэд	852	679	555	- 124	-18.3
1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд	807	615	483	- 132	-21.5
Төрөлхийн гажигтай төрсөн	6	7	2	- 5	-71.4
2500 граммаас доош жинтэй төрсөн	26	24	19	- 5	-20.8
Амьгүй төрсөн хүүхэд	4	-	3	3	-
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 нийт төрөлтөд ногдох/	4.7	-	5.4	5.4	-

2025 оны эхний 8 дугаар сард нас баралтын 210 тохиолдол бүртгэгдсэний 20 (9.5%) нь осол гэмтлийн улмаас, 79 (37.6%) нь хорт хавдрын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	Өөрчлөлт	
	Тоо			Дүн	Хувь
Нас баралт	205	226	210	-16	-7.1
Эмнэлгийн нас баралт	35	46	35	-11	-23.9
Эхийн эндэгдэл	-	1	-	-1	-
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	42	32	20	-12	-37.5
Хорт хавдрын өвчлөл нас баралт	49	68	79	11	16.2
0-1 насны эндэгдэл	4	5	5	-	-
1-5 хүртэлх насны эндэгдэл	5	2	1	-1	-50.0

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2025 оны эхний 8 дугаар сард 601 болж, өмнөх оны мөн үеэс 128 (27.1%)-аар өссөн байна.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

Халдварт өвчин	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	Өөрчлөлт	
	Хүн			Дүн	Хувь
Бүгд	763	473	601	128	27.1
Вируст гепатит	3	1	-	- 1	-
Цусан суулга	20	12	12	-	-
Гахайн хавдар	2	1	-	- 1	-
Бруцеллёз	-	1	-	- 1	-
Салхинцэцэг	202	132	215	83	62.9
Энтервируст халдвар	104	83	3	- 80	-96.4
Улаан эсэргэнэ	13	-	2	2	-
E.coli-oor/ A04.4/	-	8	-	- 8	-
Ёлом	1	-	3	3	-
Салмонеллт	19	17	8	- 9	-52.9
Гар хөл амны өвчин	119	84	48	- 36	-42.9
Нярайн бактерт үржил	-	1	-	- 1	-
Хачигт	4	1	-	- 1	-
Халдварт эритема /B08.3/	-	-	35	35	-
Сүрьеэ	44	36	34	- 2	-5.6
Тэмбүү	21	27	39	12	44.4
Заг	37	45	54	9	20.0
Трихоминиаз	42	24	16	-	-
Ковид-19	132	-	-	-	-
Улаанбурхан	-	-	131	131	-
Менингококкт	-	-	1	1	-

Халдварт өвчний тохиолдлуудаас салхинцэцгээр 83 (62.9%)-аар, заг хүйтнээр өвчлөгчид 9 (20.0%)-өөр, тэмбүү 12 (44.4%)-оор нэмэгдсэн нь өндөр өсөлттэй байна.

Шинээр халдварт улаан бурхан өвчний 131, менингококкт 1 тохиолдол бүртгэгджээ.

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 8 дугаар сарын байдлаар 180.6 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 4.6 (2.6%) мянган хүнээр өсөж, 10.1 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 45.0 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 13.6 (43.3%) мянган хүнээр өсжээ.

Түргэн тусламжийн дуудлага 10.4 мянган удаа гарсны 1.4 (13.9%) мянга нь алсын дуудлага байгаа нь өмнөх оны мөн үеэс 800 (35.7%) удаагийн дуудлагаар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар



ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 58 (17.1%)-аар өссөн байна.


2025 оны эхний 8 дугаар сарын байдлаар 398 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас 16 хүн нас барж, 83 хүн гэмтэж бэртсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 1 331.5 сая төгрөгийн хохирол учирсны 55.0 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 243 хүн холбогдон сэжиглэгдсэний 148 (60.9%) хүн нь согтуугаар, 14 (5.8%) хүн нь бүлгээр гэмт хэрэг үйлджээ.

2025 оны эхний 8 дугаар сарын байдлаар нийт 36 хүн эрүүлжүүлэгдсэн байна. Шүүхийн шийдвэрээр 172 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 398 гэмт хэргээс, илрүүлэлт 48.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.0 нэгжээр буурсан байна.

ЗУРАГ 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ



МӨНГӨ ЗЭЭЛ

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 2025 оны оны 8 дугаар сарын эцэст 3.1 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.9 хувийг эзэлж байна.

2025 оны 8 дугаар сарын эцэст Сүхбаатар аймаг дахь Монгол банкны салбарын мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 327.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 4.3 (-1.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 29.1 (9.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 168.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 5.0 (-2.9%) тэрбум төгрөгөөр буурсан, өмнөх оны мөн үеэс 6.8 (4.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт хадгаламжийн 87.2 хувь нь хугацаатай, 12.8 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

ЗУРАГ 6. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ




ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар буурчээ.

Аймгийн төсвийн нийт орлого 2025 оны эхний 8 дугаар сард 61.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 8.3 (12.0%) тэрбум төгрөгөөр буурч, төсвийн зарлага санхүүжилт 54.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.2 (4.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 7. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төгрөг



Аймгийн нийт төсвийн 52.8 хувийг орон нутгийн төсвийн орлого, 18.3 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 11.3 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 15.2 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг, 0.1 хувийг урьд оны үлдэгдэл, 2.3 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулсан аймгийн төсвийн мэдээ.




ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.7 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 8 дугаар сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 8.9 хувь, өмнөх оны эцсээс 3.6 хувь, өмнөх сараас 0.7 хувиар өссөн байна.

ЗУРАГ 8.

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 5.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 29.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 5.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.4 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 1.0 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 17.6 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 65.0 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 8.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 8 дугаар сард өмнөх оны эцсээс 3.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 5.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.6 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 10.7 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 65.0 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 8.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн

үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувь, амралт, чөлөөт цаг соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.6 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


ХҮСНЭГТ 5.

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2025 оны 8 дугаар сард

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2025 \text{ VIII}}{2024 \text{ VIII}}$	$\frac{2025 \text{ VIII}}{2024 \text{ XII}}$	$\frac{2025 \text{ VIII}}{2025 \text{ VII}}$
	хувь		
Ерөнхий индекс	8.9	3.6	0.7
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	5.3	5.2	1.4
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	0.0	2.2	0.5
Хувцас, бөс бараа, гутал	29.7	3.4	0.1
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	5.9	1.1	0.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.4	1.3	0.9
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.4	1.6	0.5
Тээвэр	1.0	2.5	0.8
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	1.4	1.3	1.3
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	0.3	-1.5	0.6
Боловсролын үйлчилгээ	0.0	0.0	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	17.6	10.7	2.6
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	65.0	65.0	0.0
Бусад бараа, үйлчилгээ	8.5	8.8	1.0

ЗУРАГ 9.

МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2025 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар өсөхөд гахайн махны үнэ дунджаар 57.4 хувь, үхрийн мах 16.7 хувь, хонь, ямааны мах 17.0 хувь, адууны мах 12.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.



ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

Хязаалан гунан үхрийн үнэ Мөнххаан суманд хамгийн өндөр буюу 2.9 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2025 оны 8 дугаар сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад атны үнэ 1.2 сая төгрөг болж, 241.7 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 1.1 сая төгрөг болж, 108.3 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 2.2 сая төгрөг болж, 654.2 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 301.2 мянган төгрөг болж, 85.8 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 190.0 мянган төгрөг болж, 35.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 6.


НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 8 дугаар сард

Төрөл	2022 VIII мян.төг	2023 VIII	2024 VIII	2025 VIII	Өөрчлөлт	
					Дүн	Хувь
Нас гүйцсэн ат	1 162.5	1 250.0	933.3	1 175.0	241.7	25.9
Соёолон үрээ	923.3	1 031.8	1 000.0	1 108.3	108.3	10.8
Хязаалан гуна	1 304.5	1 665.0	1 550.0	2 204.2	654.2	42.2
Эр хонь	203.3	213.3	215.4	301.2	85.8	39.8
Эр ямаа	135.4	136.2	155.0	190.0	35.0	22.6

Хязаалан гунан үхрийн үнэ 2025 оны 8 дугаар сард Мөнххаан суманд хамгийн өндөр буюу 2.9 сая төгрөг, Түвшинширээ суманд хамгийн бага буюу 1.4 сая төгрөг байна.

ЗУРАГ 10.


НАС ГҮЙЦСЭН ЭР ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2025 оны 8 дугаар сард, мянган төгрөгөөр



Аргалын үнэ 2025 оны 08 дугаар сард 104.0 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.5 (66.4%) мянган төгрөгөөр, хөрзөнгийн дундаж үнэ 187.5 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 52.5 (38.9%) мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 11.

МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 8 дугаар сард, төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт:

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Тооцох аргачлал: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, аймгийн худалдааны цэг, ченжүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



ГАЗАР ТАРИАЛАН

2025 оны эхний 8 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 5.1 мянган га-д үр тариа тариалалт хийсэн байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2025 оны 8 дугаар сарын байдлаар төмс 60.7 га, хүнсний ногоо 47.2 га, үр тариа 5.1 мянган га, тэжээлийн ургамал 2.1 мянган га, техникийн ургамал 6.3 мянган га-д тариалсан байна.

Үр тариа 5.1 мянган га тариалснаас 4.7 мянган га улаан буудай, 100 га арвай, 300 га овъёос, 20.0 га хөх тариа тариалсан байна.

ЗУРАГ 12.

НИЙТ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс 4.0 (6.2%) га-аар, хүнсний ногоо 1.5 (3.1%) га-аар, тэжээлийн ургамал 135.0 (6.1%) га-аар тус тус буурсан бол үр тариа 1.3 (32.9%) мянган га-аар, техникийн ургамал 3.1 (1.9 дахин) мянган га-аар тус тус өсжээ.

Хураасан хүнсний ногоо өмнөх оны мөн үеэс 49.4 хувиар өслөө.


Ургац хураалтын явцын мэдээгээр аймгийн хэмжээнд 2025 оны 8 дугаар сарын байдлаар 50 тн үр тариа, 53,5 тн төмс, 37.2 тн хүнсний ногоо хураасан байна

ХҮСНЭГТ 7.

ХУРААСАН УРГАЦ

Төрөл	Жил			Сар			Өөрчлөлт	
	2022	2023	2024	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	Дүн	Хувь
	тонн							
Үр тариа	3 478.0	2 865.0	2 395.0	-	-	50.0	50.0	-
Төмс	585.8	612.7	531.9	24.6	52.4	53.5	1.1	2.1
Хүнсний ногоо	872.2	1 060.6	569.2	25.8	24.9	37.2	12.3	49.4

ЗУРАГ 13. ХУРААСАН ТӨМС, ХҮНСНИЙ НОГОО тонноор, жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний байдлаар



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хураасан хүнсний ногоо 12.3 (49.4%) тн, төмс 1.1 (2.1%) тн-оор тус тус өсжээ.



АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 36.3 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 224.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 59.8 (36.3%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай олборлолт 61.0 (42.0%) тэрбум төгрөг, усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх салбар 1.2 (22.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.


ХҮСНЭГТ 8. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар

Салбар	Жил		Сар		Өөрчлөлт	
	2023	2024	2024 I-VIII	2025* I-VIII	Дүн	Хувь
	сая төгрөг					
Нийт дүн	221 266.6	301 412.6	165 102.6	224 954.0	59 851.4	36.3
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	181 814.1	262 956.9	145 302.5	206 331.1	61 028.6	42.0
Боловсруулах аж үйлдвэр	29 791.3	26 755.2	12 902.6	10 641.5	-2 261.1	-17.5
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	2 005.5	2 821.4	1 606.1	1 491.3	-114.8	-7.1
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	7 655.6	8 879.1	5 291.4	6 490.1	1 198.7	22.7

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 206.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 61.0 (42.0%) тэрбум төгрөгөөр өсөхөд нүүрсний олборлолт 30.0 (78.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 14.

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар, тэрбум төгрөг




Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хүрэн нүүрс, төмрийн хүдрийн баяжмал, хайлуур жонш, хайлуур жоншны баяжмал 16.7 хувиас 33.0 дахин өсжээ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт бялуу, хэрчсэн гурил, адуу, үхэр, ямааны мах, цэвэр ус, бетон зуурмаг зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 35.3 хувиас 11.6 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 9. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2024 VIII	2024 I-VIII	2025* VIII	2025* I-VIII	Өөрчлөлт		
							дүн	хувь
		тоо						
Уул уурхай, олборлох аж үйлдвэр								
Хүрэн нүүрс	мян.т	239.2	967.4	-	1 320.2	352.8	36.5	
Цайрын баяжмал	мян.т	6.7	49.1	5.6	41.8	-7.3	-14.9	
Төмрийн хүдрийн баяжмал	мян.т	-	3.6	65.1	118.8	115.2	33.0 ¹	
Хайлуур жонш	мян.т	1.2	10.7	0.5	21.0	10.3	2.2 ¹	
Хайлуур жоншны баяжмал	мян.т	3.4	21.6	6.4	25.2	3.6	16.7	
Боловсруулах аж үйлдвэр								
Талх	т	34.5	261.9	14.4	97.4	-164.5	-62.8	
Нарийн боов	т	4.5	31.6	3.2	21.0	-10.6	-33.5	
Хэвийн боов	т	1.5	23.1	0.6	13.6	-9.5	-41.1	
Бялуу	т	0.3	3.5	0.4	2.8	-0.7	-20.0	
Хэрчсэн гурил	т	9.0	62.1	0.2	1.0	-61.1	-98.4	
Малын мах	т	419.1	1 181.5	248.2	1 015.8	-165.7	-14.0	
Цэвэр ус	мян.л	10.5	46.6	78.2	541.6	495.0	11.6 ¹	
Бууз, банш	т	84.9	534.6	0.6	3.7	-530.9	-99.3	
Бусад төрлийн бэлтгэсэн хоол, хүнс	т	3.9	13.3	0.2	1.7	-11.6	-87.2	
Бетон зуурмаг	м3	1 410.0	4 370.0	1 486.0	5 912.0	1 542.0	35.3	

ЗУРАГ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2025 оны эхний 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 339.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 87.9 (35.0%) тэрбум төгрөгөөр өслөө.

ХҮСНЭГТ 10. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

Салбар	Жил		Сар		Өөрчлөлт	
	2023	2024	2024 I-VIII	2025* I-VIII	Дүн	Хувь
	сая төгрөг					
Нийт дүн	432 086.8	447 687.6	251 113.4	339 012.5	87 899.1	35.0
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	391 677.9	406 886.4	230 649.9	318 800.6	88 150.7	38.2
Боловсруулах аж үйлдвэр	29 697.8	27 053.5	12 436.6	10 608.4	-1 828.2	-14.7
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	2 453.5	3 893.7	2 141.7	2 106.7	- 35.0	- 1.6
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	8 257.6	9 854.1	5 885.2	7 496.8	1 611.6	27.4

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 87.9 (35.0%) тэрбум төгрөгөөр өсөхөд хүрэн нүүрс олборлолт 47.1 (2.1 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 16.

УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, сая төгрөг



Гадаад зах зээлд 2025 оны эхний 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 319.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 315.5 тэрбум нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 36.5 хувийг нүүрс олборлолтын салбар, 51.6 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 11.9 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.

2025 оны эхний 8 дугаар сарын гүйцэтгэлээр 41.8 сая.квт.цаг эрчим хүчийг дамжуулан авч, 10.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 8 дугаар сарын гүйцэтгэлээр 1.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.3 (19.3%) тэрбум төгрөгөөр өслөө. Иргэдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 53.8 хувийг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 26.4 хувийг хувцас үйлдвэрлэл, 10.1 хувийг мужааны зориулалттай модон эдлэл үйлдвэрлэл, 9.7 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нарийн боов, бялуу, хэрчсэн гурил, цэвэр ус, хучлага, даавуун уут, тор, ажлын хувцас, бэлтгэлийн хувцас, оёмол плате, банзал, малгай, гутал, модон сандал, гэрийн мод болон бусад хэрэгсэл, блок зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3.6 хувиас 6.7 дахин өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Тайлбар: Хувиараа үйлдвэрлэл эрхлэгч иргэн болон ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Статистикийн хэлтэс, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал; Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал;

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ

БҮЛЭГ

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

	Ерөнхий тэмдэглэл	
	Үндсэн үзүүлэлтүүд	
I	Хүн ам	С.Мөнхбаяр
II	Хөдөлмөр	С.Мөнхбаяр
III	Нийгмийн халамж	С.Мөнхбаяр
IV	Эрүүл мэнд	С.Мөнхбаяр
V	Гэмт хэрэг	Б.Сумъяа
VI	Мөнгө, банк	Б.Сумъяа
VII	Орон нутгийн төсөв	С.Мөнхбаяр
VIII	Үнэ	Б.Сумъяа
IX	Хөдөө аж ахуй	О.Ундрах
X	Аж үйлдвэр	С.Мөнхбаяр
	Хавсралт хүснэгтийн жагсаалт	
	Хавсралт хүснэгтүүд	

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН: Хэлтсийн мэргэжилтэн О.Ундрах

ХЯНАСАН: Хэлтсийн дарга Т.Эрдэнэбат

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

II. ХӨДӨЛМӨР

- II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар
- II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар, боловсрол, насны бүлгээр
- II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар
- II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар
- II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, сумаар
- II.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН салбарын ангиллаар, сумаар

III. НИЙГМИЙН ХАЛАМЖ

- III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

IV ЭРҮҮЛ МЭНД

- IV.1 ЭРҮҮЛ МЭНД
- IV.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар
- IV.3 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

V ГЭМТ ХЭРЭГ

- V.1 БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ
- V.2 БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ, сумаар
- V.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИД
- V.4 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИД, сумаар

VI МӨНГӨ, БАНК

- VI.1 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст

VII ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- VII.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО
- VII.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА
- VII.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар
- VII.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар

VIII ҮНЭ

- VIII.a.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС
- VIII.a.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны дундаж үнэ
- VIII.б МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сумаар, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар

IX ГАЗАР ТАРИАЛАН

- IX.I ТАРИАЛСАН ТАЛБАЙ, сумаар, га-р
- IX.II ХУРААСАН УРГАЦ, сумаар, тн-оор

X АЖ ҮЙЛДВЭР

- X.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар
- X.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар
- X.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар
- X.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар
- X.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр
- X.6 ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ
- X.7 ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2023		2024		2025	өөрчлөлт	
	VIII	XII	VIII	XII	VIII	дүн	хувь
	тОО						
Нийт дүн	81	302	209	234	386	177	84.7
Асгат	1	2	13	12	14	1	7.7
Баяндэлгэр	-	8	1	1	1	-	-
Дарьганга	-	3	1	2	2	1	2.0 ¹
Мөнххаан	-	83	1	21	-	-	-
Наран	6	4	15	5	4	-11	-73.3
Онгон	2	2	-	2	-	-	-
Сүхбаатар	1	7	35	1	40	5	14.3
Түвшинширээ	8	3	14	15	28	14	2.0 ¹
Түмэнцогт	2	2	1	16	2	1	2.0 ¹
Уулбаян	-	26	7	2	7	-	-
Халзан	-	-	-	8	2	-	-
Эрдэнэцагаан	10	33	9	-	16	7	77.8
Баруун-Урт	51	129	112	149	270	158	2.4 ¹

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
			тОО													
Нийт дүн	386	203	3	44	12	13	150	94	53	17	31	92	124	83	33	23
Асгат	14	10	-	2	1	2	2	4	1	2	1	3	5	3	1	1
Баяндэлгэр	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	1	-
Дарьганга	2	-	-	-	-	-	1	-	1	-	-	-	1	1	-	-
Мөнххаан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Наран	4	2	-	1	1	-	-	-	-	2	-	1	1	1	-	1
Онгон	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	40	16	1	7	1	-	14	15	2	-	9	14	6	9	1	1
Түвшинширээ	28	20	-	3	-	-	1	14	10	-	1	9	14	2	-	2
Түмэнцогт	2	1	-	1	-	-	1	-	-	-	1	-	1	-	-	-
Уулбаян	7	1	-	1	-	-	2	1	1	2	-	2	5	-	-	-
Халзан	2	1	-	1	-	-	-	1	-	-	-	-	1	1	-	-
Эрдэнэцагаан	16	9	-	-	-	1	2	5	8	-	2	2	5	5	1	1
Баруун-Урт	270	143	2	28	9	10	126	54	30	11	17	61	85	61	29	17

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2023		2024		2025	өөрчлөлт	
	I-VIII	XII	I-VIII	XII	I-VIII	дүн	хувь
	тоо						
Нийт дүн	1 097	1 870	1 071	1 874	1 141	70	6.5
Асгат	54	70	67	159	45	-22	-32.8
Баяндэлгэр	4	33	1	62	1	-	-
Дарьганга	70	96	80	138	28	-52	-65.0
Мөнххаан	4	96	35	87	22	-	-37.1
Наран	68	76	62	79	36	-26	-41.9
Онгон	79	135	2	85	29	-	13.5 ¹
Сүхбаатар	55	106	50	51	99	49	98.0
Түвшинширээ	178	184	58	165	116	58	2.0 ¹
Түмэнцогт	7	44	10	76	13	3	30.0
Уулбаян	19	88	20	32	23	-	15.0
Халзан	-	31	9	26	17	-	88.9
Эрдэнэцагаан	89	171	72	72	26	-46	-63.9
Баруун-Урт	470	740	605	842	686	81	13.4

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

Сум	2023		2024		2025	өөрчлөлт	
	I-VIII	XII	I-VIII	XII	I-VIII	дүн	хувь
	тоо						
Нийт дүн	316	764	453	1 022	555	102	22.5
Асгат	49	62	38	120	30	-8	-21.1
Баяндэлгэр	1	22	-	60	-	-	-
Дарьганга	50	73	77	133	24	-53	-68.8
Мөнххаан	1	9	48	79	19	-29	-60.4
Наран	31	35	41	55	29	-12	-29.3
Онгон	45	97	2	83	24	22	11.0 ¹
Сүхбаатар	-	43	4	4	46	42	10.5 ¹
Түвшинширээ	45	48	34	126	66	32	94.1
Түмэнцогт	-	32	-	51	4	4	-
Уулбаян	1	44	10	21	8	-2	-20.0
Халзан	-	31	9	18	11	2	22.2
Эрдэнэцагаан	66	114	41	41	4	-37	-90.2
Баруун-Урт	27	154	149	231	290	141	94.6

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, сумаар

	2023 I-VIII				2024 I-VIII				2025 I-VIII				өөрчлөлт	
	Бүгд	Үүнээс			Бүгд	Үүнээс			Бүгд	Үүнээс				
		Байнгын	Түр	Улирал		Байнгын	Түр	Улирал		Байнгын	Түр	Улирал	дүн	хувь
	Тоо													
Нийт дүн	694	439	237	18	312	80	219	13	362	158	175	29	50	16.0
Асгат	61	28	33	-	38	8	30	-	17	7	10	-	-21	-55.3
Баяндэлгэр	6	-	6	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарьганга	112	69	43	-	54	9	43	2	27	9	18	-	-27	-50.0
Мөнххаан	44	22	17	5	-	-	-	-	4	4	-	-	4	-
Наран	74	30	39	5	29	7	22	-	17	5	12	-	-12	-41.4
Онгон	15	11	4	-	-	-	-	-	11	3	8	-	11	-
Сүхбаатар	11	11	-	-	2	2	-	-	9	-	9	-	7	4.5 ¹
Түвшинширээ	87	49	33	5	51	20	28	3	58	31	19	8	7	13.7
Уулбаян	-	-	-	-	24	1	20	3	14	8	1	5	-10	-41.7
Халзан	-	-	-	-	67	0	67	0	9	6	3	-	-58	-86.6
Эрдэнэцагаан	170	131	36	3	19	18	0	1	19	1	18	-	-	-
Баруун-Урт	114	88	26	-	28	15	9	4	177	84	77	16	149	6.3 ¹

II.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, сумаар

Сум	2025 I-VIII		Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар													
	Бүгд	Эмэгтэй	Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн, загас агнуур	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Мэдээлэл, холбоо	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Урлаг, үзвэр, тоглоом наадам	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн хэмжээг нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	
																Тоо
Нийт дүн	362	185	43	0	45	2	0	16	31	0	3	14	0	0	0	
Асгат	17	10	1	-	-	-	-	3	2	-	-	-	-	-	-	
Дарьганга	27	17	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Мөнххаан	4	3	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Наран	17	8	-	-	3	-	-	4	-	-	1	-	-	-	-	
Онгон	11	5	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	
Сүхбаатар	9	5	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Түвшинширээ	58	23	12	-	20	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Уулбаян	14	3	-	-	-	-	-	-	4	-	-	-	-	-	-	
Халзан	9	6	-	-	-	-	-	-	-	-	-	9	-	-	-	
Эрдэнэцагаан	19	11	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Баруун-Урт	177	94	29	-	21	1	-	9	25	-	2	5	-	-	-	

III. НИЙГМИЙН ХАЛАМЖ

III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2023 I-VIII		2024 I-VIII		2025 I-VIII		Өөрчлөлт	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Дүн	Хувь
Бүгд	24 056	8 290.8	25 813	10 867.8	20 948	12 745.8	1 878.0	17.3
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	4 744	5 122.4	4 885	7 744.3	5 169	8 926.2	1 181.9	15.3
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 423	3 206.2	1 489	4 052.1	1 519	4 631.4	579.3	14.3
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 310	1 803.0	2 694	3 595.5	2 982	4 231.0	635.5	17.7
Асаргааны тэтгэмж	1 182	1 147.6	1 377	2 795.5	1 502	3 309.1	513.6	18.4
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	205	195.6	236	481.8	256	573.6	91.8	19.0
Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	704	623.0	837	1 660.6	937	1 964.8	304.2	18.3
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	232	284.9	266	550.5	267	663.5	113.0	20.5
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	18	19.5	15	46.3	18	48.5	2.2	4.7
